

ТҮҮХ, СОЁЛ,
БОЛОВСРОЛ,
ШАШИН

ЮАН ГҮРЭН МӨХСӨНИЙ ДАРААХ МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦАА

Н. Ариунгуа

1368 онд Жу Юаньжанаар удирдуулсан Хятадын ард түмэн монголын эзлэн түрэмгийллийн үр дүнд 150-иад жил тогтсон харийн ноёрхолыг түлхэн унагаж Хятад төр улсаа сэргээн Мин улсыг тун хагласан билээ.

Монголын Юан гүрэн мөхөж Монголын феодалууд төрөлх нутагтаа буцаж ирснээр монгол-хятадын харилцаанд үндсэн өөрчлөлт гарч улмаар тэрхүү харилцаа нь бие даасан хоёр орны үндсэн дээр үргэлжлэн хөгжих болжээ. Чингэхдээ энэхүү гадаад улс төрийн харилцаа нь хоёр орны тухайн улс төрийн байдлын явцаар тодорхойлогдон заримдаа түүнд нөлөөлсөөр иржээ.

Юан гүрэн мөхөж Монгол орон эдийн засаг, улс төрийн хувьд дахин бие даасан цогцос болсноор Монголын нийгмийн өмнө шинэ шинэ асуудлууд тулгаран гарч иржээ. Чухам энэ үед Монгол орны эдийн засгийн сул байдал тэр даруй хурцаар илэрсэн байна. Учир нь монголчууд аж ахуйгаасаа гарсан бүтээгдэхүүнийг борлуулж, өөртөө хэрэгтэй тариалан ба гар үйлдвэрийн бүтээгдэхүүн олж болох бараг цорын ганц Хятадын зах зээлээс таслагдсан ажээ.

Улс төрийн амьдралд өөрчлөлт гарсан нь дээр үед захирч байсан харь орон, газар нутгаа алдаж тал нутагтаа ирсэн их хааны сүр жавхлан, улс төрийн эрх мэдэл, ялангуяа эдийн засгийн хүч нь ихэд доройтон, аливаа байдлаараа жирийн феодалаас ялгагдахгүй болж эхэлжээ. Тэд урьдын адил феодалуудад «идэх хот» гэх мэт соёрхол өгөх зэргээр өөрийн эрх мэдэлдээ феодалуудыг барьж байх эдийн засгийн ямар ч хүчгүй болсон ажээ. Нөгөө талаас их хаан, түүний шадар түшмэлүүд Хятадаас эх нутагтаа буцаж ирснээр монгол нутагтаа оршин байсан феодалуудын эрх ашгийг хөндөж тэдний зүгээс хүчтэй эсэргүүцэл гарч улмаар засаг төр, эрх мэдлийн төлөө тэмцэл өрнөж эхэлжээ. Монголын нийгмийн хөгжлийн энэхүү түүхийн шинэ нөхцөлд Хятад улс гадаад хүчин зүйлийн хувьд онцгой үүрэг гүйцэтгэж байв. Энэ үед Монголын феодалууд Хятад дахь ноёрхлоо эргүүлэн авах хэмээн хэд хэдэн оролдлого хийжээ¹.

1370 онд Монголын их хааны орыг Юаны сүүлчийн эзэн хаан Тогоон Төмөрийн хүү Аюушридар залгаж Билэгт хаан хэмээн өргөмжлөгдөж, Монголын улс төрийн төв дахин Хархорумд төвлөрөх болжээ.

Аюушридар Хархорумд цэрэг эрээ бүртгэж Хятадыг эзлэн авч эрх мэдлээ сэргээн бэхжүүлэхийг оролджээ. Монголын нэлээд цэргийн хүч Хятадын нутаг дэвсгэр дээр байрлаж байсан нь энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байв.

Мин улс байгуулагдсаны даруй хятадын улс төрийн гол зорилго «их дээрэмчдийг хөөн Хятад улсаа сэргээхэд» чиглэгдэж байсан бол Монголын гол хүч Хятадын нутаг дэвсгэрийг орхин гарсны хойно монголчуудын хүчийг сарниулан үндэсний нэгдэл дээр хүчжин бэхжих явдалд нь саад хийхэд чиглэгдэх болжээ. Мин улс монголчуудын довтолгооныг цэргийн хүчээр зогсоох, нөгөө талаас Монгол

дахь дотоод улс төрийн байдал тайван бус байгааг ашиглан монголын феодалуудын хооронд яс хаях тэдгээрийн заримыг нь бэлэг шангаар өөртөө татах бодлогыг явуулах болов. Энэ үед үндсэн хэсгээсээ таслагдан Хятадын нутаг дэвсгэрт байрлаж байсан Монголын феодалууд санаа сэтгэл алдагдаж мөн Хятадын цэргийн давамгай хүчинд автагдан Хятадын талд бууж өгөх явдал гарч байв. Мин улсын эзэн хаан Жу Юаньжан Хятадын нутаг дэвсгэрт байрлаж байсан Монголчуудын талаар нарийн уян хатан бодлого явуулж, өөрийн талд барьж байхыг оролдож эхэлжээ.

Тухайлбал: Жу Юаньжан монголчуудыг Хятад улсын төрийн албанд зүтгэхийг албан ёсоор зөвшөөрсөн ажээ. Хятадын эзэн хааны зарлигт «Монгол, өнгөт нүдэт үндэстнүүд хуася (хятад үндэстний өвөг дээдсийг хэлж байна. Н. А.) үндэстэн биш боловч (Бидний) адил тэнгэрийн доор аж төрж төр ёсыг дагаж чадах учир хэрэв тэдний дотор түшмэл болохыг хүсэгчид байваас хятад хүний адил үзэж тэтгэнэ»² гэжээ. Мөн Хятад улс монголчуудын дургүйцлийг дарж санаа сэтгэлийг нь тайван байлган тэднийг хазаарлан барьж байхад онцгой анхаарал тавьж байсны нэг жишээ бол Хятадын зарим сайд түшмэлүүд бууж өгсөн Монголчуудыг хил орчим үймээн дэгдээхээс сэргийлэн тэднийг өмнө зүг шилжүүлэн нутаглуулах тухай саналыг эзэн хаандаа айлтгахад Жу Юаньжан «...бүдүүлгүүд бүгд хүйтэн сэрүүн газар амьдарч дассан учир тэднийг халуун газар шилжүүлэн суулгаваас тэдний төрөлхийн зан төрх алдагдахад хүрч дургүйцэн үймээн самуун гаргаж захирагдахгүй болно. Иймд тэднийг баримтлан захирахын тулд хил орчим адуу малд нь тохиромжтой бэлчээр газар сонгон олгох нь зүйтэй бөгөөд тэд өөрсдийн дассан сурсан газраа амьдарваас нам тайван байх болно» гэж түшмэдүүдийнхээ саналыг хүлээн аваагүй байна.³ Ийнхүү Хятад нутагт үлдсэн Монголчуудын талаар явуулж байсан бодлого нь тэдний санаа сэтгэлийг засаж, дургүйцлийг дарахад чиглэсэн төдийгүй Монгол дахь феодалуудтай харьцах нэгэн хэлбэр загварыг бий болгож тэднийг өөрийн талд татах бодлогын үндэс болсон ажээ. Ер нь Хятадын төрийн бодлогын байдлаас үзэхэд дотоод дахь нийгмийн харьцааны хэлбэр загварыг гадаад бодлогын хүрээнд аваачиж тавьдаг байсан бөгөөд энэ нь чухам «Дэлхий дахиныг илбэн тохинуулах хаант төр» хэмээх хятадын төрийн үзэл суртлаас урган гарсан ажээ.

Өгүүлж буй үед Мин улс эдийн засаг, улс төрийн хувьд хараахан батжиж чадаагүй учир Монголчуудтай харьцаагаа цэрэг дайны аргаар биш улс төрийн замаар зохицуулахыг илүү эрхэмлэж байжээ. Энэхүү зорилгоор Жу Юаньжан Монголын хаан Аюушридар хэд хэдэн удаа зарлиг илгээж байв. Ер нь Хятад улс хүч чадлын хувьд өөрөөсөө давамгай, эсвэл тэнцүү улс оронтой улс төрийн аргаар харьцаагаа зохицуулахыг оролдож байв. Чингэхдээ «дэлхий дахиныг илбэн тохинуулах» номлолын дагуу Хятадын эзэн хааны энэрэнгүй үзэл «бүдүүлгүүдийн» нутаг дэвсгэрт хүрч тэднийг илбэн засаж улмаар хятадын эзэн хаанд захирагдах хүслээ илэрхийлэн хаанд «алба» барих замд оруулах ёстой ажээ. Гэвч бодит амьдрал тэрхүү номлолтой хол зөрж байсан бөгөөд Хятад улс амьдрал номлол хоёрыг «ойртуулах» зорилгоор улс төрийн янз бүрийн аргад шилждэг байжээ. Тухайлбал хүчирхэг нүүдэлчин улсын хаанд гүнжээ өгч ургын холбоо тогтоож ах дүүгийн барилдлагатай болгохыг оролдохдоо нүүдэлчин улс Хятадын хувьд «дүү улс» болдог байжээ. Хүч тэнцүү нүүдэлчидтэй харьцаа тогтоохдоо тэдний эдийн гачигдлыг ашиглан зөвхөн алба барих үндсэн дээр худалдаа хийхийг зөвшөөрч байжээ. Нөгөө талаас «ургын холбоо», «алба» гэдэг нь нүүдэлчдийн довтолгооноос өөрийгөө

хамгаалах нэгэн арга болж байжээ. Тогоон Төмөр хааныг ялагдахад нэгэн түшмэл хаандаа ийнхүү айлтгасан байдаг: «Хан, Тан улсаас эхлэн бүдүүлгүүд Хятадад зовлон учруулж байв. Тэдний сэтгэлийг ургийн холбоо, эсвэл үнэт бэлэг сэлтээр аргацаан хуурч байв» гэжээ.⁴

Дээрх зорилгоор Хятадын эзэн хаан Жу Юаньжан Аюушридар хаан руу хэд хэдэн удаа элч илгээсэн боловч Монголын тал хүлээн аваагүй бөгөөд Хятадад аюул занал учруулсан хэвээр байжээ. Энэхүү нөхцөлд Мин улсын засгийн газар 1372 онд 3 чиглэлээр Монгол руу үлэмж хэмжээний цэрэг илгээсэн байна. Хятадын цэрэг гурван замаар Монголд цөмрөн орж Монголын цэрэг эсэргүүцэн тулалдсан боловч ялагдаж буруулсанд Хятадын цэрэг Орхон гол хүртэл нэхэн хөөжээ. Гэвч удалгүй Хятадын тал цэргээ татаж авчээ. Монголын цэрэг хэдийн нэлээд хохирол үзсэн боловч бүрмөсөн бут цохигдсонгүй дараа жилээс монголчууд Хятадын нутаг руу Шаньси, Хуйжоу, Ляо нин, Хэбэй ойролцоо газраар довтолж, Хятад улс стратегийн хувьд чухал нутгаа алджээ. Тэдгээр нь Синхэ, Хэбэй муж дахь Фунин тойрог, Ляонин муж дахь Суйжун газар болно. Дээрх нутгийг алдсанаар Хятадын нийслэлд баруун хойт, зүүн өмнө талаар аюул учирч, Ляо дун мөн таслагдахад хүрчээ. Энэхүү нөхцөлд Мин улс монголчуудтай найрамдахыг чухалчилж дээр баривчлагдсан Аюушридар хааны хүү Майдарбалыг барианаас суллаж буцаасан ажээ. Монголчууд ч гэсэн хүчээ сэлбэх мөн дотоод улс төрийн хямралдааныг дарах, улс орноо төвхнүүлэх хэрэгтэй байсан учир Хятадын саналыг хүлээн авч хоёр тал 1378 он хүртэл дайны ажиллагаагаа зогсоожээ. Хятадын аян дайны гол зорилгын талаар Серройс Х. бичихдээ «Монгол руу хийсэн Хятадын аян дайн нь үнэн чанартаа улс орныг эзлэн авч тэнд ноёрхлоо тогтоох санаархал байгаагүй, туршилтын төдий чанартай байсан⁵ гэжээ. Н. П. Свистунова тухайн үеийн Хятадын гадаад бодлогын талаар Хятад улс үндэсний аюулгүй байдлын үүднээс монголчуудыг бүрмөсөн бут цохиж хойт хязгаарынхаа дагуу хамгаалалт байгуулах шаардлагатай байв. Чухамхүү нэгдэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Мин улсын эхэн үед Монгол руу их хэмжээний аян дайн хийжээ⁶ гэж бичжээ. Үнэхээр энэ үед Хятадын гадаад, дотоод улс төрийн байдал (Хятадын нутаг дэвсгэр дээр үлэмж хэмжээний Монголын цэрэг бөөгнөрсөн байсан. Жу Юаньжаныг эсэргүүцсэн хятадын улс төрийн бүлгүүд бий болсон, эдийн засаг нь уналтын байдалд байсан зэрэг) Монголыг шууд эзлэн авч тэнд ноёрхлоо тогтоох бололцоог хараахан бүрдүүлээгүй байж болох юм. Ю. Л.Кроль Дундад улсын гадна байгаа газар нутгийг хятадууд үл тоомсорлон тэдгээрийг эзлэн авч эзэмших шаардлагагүй гэж үзэж байсан гэж бичжээ.⁷ Монголчуудыг бут цохиж тэднийг өөрийн улс төрийн эрхшээлд оруулах гэсэн Хятадын оролдлого талаар өнгөрч Монгол-Хятадын хооронд эрх тэгш үндсэн дээр найрамдалт харилцаа тогтсон ажээ. Энэхүү найрамдалт харилцаа Аюушридар хааныг нас бартал үргэлжилсэн бөгөөд Жу Юаньжан Аюушридар хааныг нас барахад эмгэнэл илэрхийлсэн зарлигтаа: Монгол, Хятадын хооронд тогтсон найрамдалт харилцааг үнэлэн ийнхүү бичсэн байдаг. Эрхэмсэг ван (Аюушридарыг хэлж байна — Н. А.) Говь газраа захирч, миний бие Дундад улсаа захирч байв. Эрхэмсэг ваны олон түшмэдүүд нь тууштай бодлого баримталснаар хил хязгаарт түгшүүр үймээн үгүй байлаа. Өнөө эрхэм вантныг говь нутагт оршуулах гэж сонсоод ихэд гашуудан, улмаар тусгайлан элч илгээж эмгэнэл илэрхийлэн нас барсны хойноос мөргөл үйлдэв гэжээ.⁸ Хятадын эзэн хааны энэхүү зарлигт тус тусын газар нутгийг захирахыг хүлээн зөвшөөрөхийн хамт «тэнгэрийн хөвүү

ний дээд эрх» гэгчийг ёс төдий боловч тэмдэглэсэн байдаг. Хятадын гадаад улс төрийн бодлогыг судалсан эрдэмтэд эрх тэгш үндсэн дээр байгуулагдсан хийгээд Хятадын зүгээс «тэнгэрийн хөвүүний дээд эрх» гэгчийг ёс төдий хадгалах гэсэн оролдлого бүхий харьцааг Хятадын гадаад улс төрийн бодлогын үүднээс «имманентный сюзеренитет» хэмээн томъёолсон байдаг. Хэрэг дээрээ энэ нь эрх тэгш хоёр орны харилцаа байсан бөгөөд «Тэнгэрийн хөвүүний дээд эрх» гэгч нь Хятадын гадаад улс төрийн концепцийг бодит байдалтай нийцүүлэх оролдлого байсан ажээ.

Аюушридар нас барснаар Монголд хаан ширээний төлөө тэмцэл өрнөж энэхүү тэмцэлд хааны шууд буюу шууд бус угсааны ноёд оролцжээ. Тухайн үеийн монголын дотоод улс төрийн байдлыг Хятадын эзэн хаан Жу Юаньжанаас монголын жанжин Нагачу, Халачжан, Манцзилур (сүүлийн хоёр нэр хятад дуудлагаар авав) нарт бичсэн илгээмжээс үзэж болно. Тэрхүү захианд юаныханы дунд хэрэг төвөг мандан олон түшмэд хааны удам угсааг орхигдуулан өөрсдөө арга сүвэгчилж бүхнийг эзэмдэхийг бодож байна гэж бичсэн байдаг.⁹

Хятад улс Монголын улс төрийн байдал тогтворгүй болсныг ашиглан монголын хаан ширээнд өөрийн төлөөний хүнийг тавьж улмаар монголчуудыг цэргийн хүчээр биш улс төрийн аргаар хазаарлан барьж байхыг сонирхож байв. Үүнийг хятад сурвалж бичигт «бүдүүлгүүд хаан суулгахдаа эргэлзэн мөн ордны (Хятад улсын) хүслийг үл ойшоон амар жимэр болсонгүй»¹⁰ гэснээс харж болох байна.

Гэвч Хятадын оролдлого нь талаар болжээ. «Мин ши лу»-д тэмдэглэснээр 1379 оны 6-р сараас 9 сар хүртэлх хугацаанд Хятадын эзэн хаан Монгол руу гурван удаа элч залж хоёр удаа эмгэнэл илэрхийлж, нэг удаа төрийн түшмэлийг элчээр томилон зарлиг хүргүүлсэн боловч тэдгээр элч нар нь ор сураггүй алга болсон гэж тэмдэглэжээ.¹¹

1378 онд Монголын хаан ширээнд Аюушридар хааны дүү Төгстөмөр (1378—1388) суужээ. Энэ үед монгол-хятадын харилцаа дахин хурцдаж дайны ажиллагаа эхэлжээ. Төгстөмөр хаан Хархорин, Инчааны ойролцоо их цэрэг хуримтлуулан Хятад руу уулгалж байв. Мин улс мөн монголчуудын талаар явуулж байсан үйл ажиллагаагаа идэвхижүүлж Ляонин мужийн хошуу Пинцюань, Чаян, Чифэн, Өмнөд Монголын Харчин хошууг хамарсан бүс нутгийг эзлэн авчээ. 1380 онд Хятадын жанжин Му Иннаар удирдуулсан их хэмжээний цэрэг Монголын нутаг дэвсгэр руу цөмрөн орж Хархоринг сүйтгэн их хэмжээний хүн олзлон авч буцжээ.

1381 оноос 1387 он хүртэлх хугацаанд Монгол-Хятадын хооронд том хэмжээний тулалдаан болоогүй байна. Төгстөмөр хаан ширээ залгамжилснаар Монголын дотоод улс төрийн тэмцэл зогсоогүйгээр үл барам харин нэлээд гүнзгийрсэн бололтой. Энэ үеэр дотоодын хямралдааны улмаас Монголын хэсэг феодалууд хүн ардынхаа хамт Хятадаас өмөг түшиг гуйж ирж байсан байна.

Монголын улс төрийн байдал тогтворгүй байгааг Хятадын тал ашиглан 1388 онд 130 мянган цэрэг Инчан хотын зүг илгээжээ. Энэ байлдаанд Монголын цэрэг дарагдаж олон хүнээ алуулж Төгстөмөр хаан их хүү, шадар түшмэдүүдийнхээ хамт Хархорин руу зугтаж тэндээсээ Туул гол хүрсэн боловч Аригбухын угсааны ноён Есдөр¹² тэднийг довтолж энэ тулалдаанд хааны тал дийлэгдэн Төгстөмөр цөөн хүний хамт тулалдаанаас зугтан гарч цаашдаа Мархацза зэрэг жанжнаар удирдуулсан 3 мянган цэргийн хүчтэй нэгдэхийг завдсан байв.

Хөхтөмөр жанжин мөн цэргийн хамтаар тэдэнтэй нэгдэх санаатай байжээ. Гэвч тэр үеэр 3 хоног дараалан их цас орж Төгстөмөр

хаан замд гарч чадалгүй саатжээ. Яг энэ үеэр Есдөр да ван Хурхудайн ач Болойн нэгэн түшмэдийг Төгстөмөрийг нэхэн хөөхөөр илгээжээ. Тэрээр Төгстөмөрийг баривчлан нум сумны сураар боож алжээ.¹³

Төгстөмөр хаан хорлогдсоноор Монголын улс төрийн байдал туйлын тогтворгүй болж түүний жанжин Нэцэлай, Ширмэн нар дотоод улс төрийн хямралдаанаас болж Хятадад дараа дараагаараа бууж өгчээ.

Үүнээс өмнө Хятадын засгийн газар Ляодуний орчмоор Хятадын хил хязгаарыг довтлон байсан Нагачу тэргүүтэй Монголын цэргийн хүчийг бут цохихоор шийдвэрлэж 1387 онд Чанчун хотын орчим тулалдаж Хятадын хүч давамгай байсан учир бууж өгчээ.

Төгстөмөр хаан ялагдсанаар монгол-хятадын харилцаанд үндсэн өөрчлөлт гарч монголчууд Хятад дахь ноёрхолоо дахин сэргээх гэсэн санаархлаасаа ухарч тухайн үеийнхээ цэрэг улс төрийн байдалдаа захирагдан Хятадтай харилцаа тогтооход хүрчээ. Монголд улс төрийн бутрал даамжирснаар Монголын гадаад улс төрийн нэгдмэл чанар алдагдаж улмаар улс төрийн тодорхой бүлгүүдийн эрх ашгийг илэрхийлэх болжээ. Тэдгээр хүчнүүдийн зарим нь дотоод улс төрийн тэмцэлдээ Хятадаас өмөг түшиг хайх мөн эдийн засгийн гачигдлаа тайлах зорилгоор «алба барих» замаар Хятадтай худалдаа хийж байсан бол нэгдсэн хаант төрийн үзлийг баримтлагч хүчнүүд улс төр, эдийн засгийн хувьд өөрийн эрх ашигт нийцүүлэх үндсэн дээр Хятадтай харьцаа тогтоохыг зорьж болзлоо Хятадад тулгахыг оролдон байн байн уулгалж байв. Ийнхүү Монголын Юан улс мөхсөний дараах Монгол, Хятадын харилцааны байдлыг авч үзвэл Монголын феодалууд Хятадаас хөөгдөн гарч эх нутагтаа ирсний дараа Хятад дахь ноёрхлоо дахин сэргээхийг оролдсон боловч тэр нь бүтээгүй ажээ.

Мин улс монголын нутагт үлэмж тооны цэргийг явуулж Монголыг бүрмөсөн эзлэн авахыг оролдсон боловч монголчуудын зүгээс хатуу цохилтыг авч байжээ. Хятадын эрх баригчид, өөрийн нутагт монголын үлэмжхэн тооны цэрэг үлдэн хоцорсон ба Хятадын дотоод байдал сайн бэхжээгүй, монголчуудын хүчин чийрэг байсан зэргийг харгалзан монголчуудыг цэргийн хүчээр номхотгох бололцоогүйг мэдэж, улс төр, эдийн засгийн шахалт хавчилтыг үзүүлэх, монголчуудын дотоод хямралыг аль болох дэвэргэн хүчийг нь бутраах зэрэг «тайван» аргыг хэрэглэсэн байна.

Монголын феодалууд ч, Хятадад тусгаар тогтнол сэргэн үндэсний төр улс тогтносон явдал нь улс орноо хамгаалах хүч чадлыг бий болгосныг ойлгожээ. Монголын дотоодын дажин хямрал нь тэдний тамир тэнхээг ихээхэн сулруулж, нэгдсэн хүчээр Хятадыг буулган авах хүч бололцоо алдагдсаныг харгалзан хүч хэрэглэх биш харин найрамдан, улмаар эдийн засгийн мухардмал байдлыг гэтлэн давахыг оролдох байр сууринд шилжсэн байна.

Ийнхүү Монгол, Хятадын хүчин тэнцсэн явдал нь аль алины зүгээс харилцааг тухайн байдалд нийцүүлэн найрамдах, байлдах зэргээр харилцахад хүргэж байжээ.

1. Мин ши 22-р боть, 91-р дэвтэр, 1-р тал

2. «Мин тай, зу шилу» Цз. 36.

3. «Мин тай зу ши лу». Цз. 59, Хун у-гийн 3-р он 12-р сарын шар морь өдөр

4. Мин шилу Хун у-гийн 21-р он 8-р сарын шар луу өдөр.

5. Henry Serrugs sino-mongol relations during the Ming. Bruxelles, 1967, p. 6

6. Свистунова, Н. П. Организация пограничной службы на севере Китая в эпоху Мин «Китай и соседи». М, 1970, с. 177,